



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/30

Чойр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.2, Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 03 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан “Уурын ариутгалын автомашин”-ыг ашиглалтад хүлээн авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Н.Батцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Х.Алтанцэцэг (Орон нутгийн өмчийн газрын Орон нутгийн өмч хариуцсан ахлах мэргэжилтэн)

З.Оч-Эрдэнэ (Онцгой байдлын газрын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, техник хэрэгсэл хариуцсан мэргэжилтэн)

(Зөвшилцсөнөөр)

Н.Мөнхнаран (Авто тээврийн төвийн дарга)

(Зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Г.Энххишиг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

2. Тус автомашиныг техникийн тодорхойлолтод заагдсан тоо хэмжээ, үзүүлэлтэд тавигдсан шаардлагыг хангуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээн авч, үр дүнг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Н.Батцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

